



АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/149

Эрдэнэбулган сум

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын
албаны дүрэм, бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 1.1, 4.1, 8.3, Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолын 4.12 заалтууд, аймгийн Засаг даргын 2021 оны А/902 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсгээс гаргасан чиг үүргийн шинжилгээний тухай саналыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрмийг нэгдүгээр хавсралтаар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Албаны дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлж, нэмэлт өөрчлөлт хийлгэхийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргад даалгасугай.

3. Албаны бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан ажилтан албан хаагчдын цалингийн сан, бусад зардлыг орон нутгийн төсөвт тусган батлуулж, санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад тус тус даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/676 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭРЭННАДМИД

6513910446

Архангай аймгийн Засаг даргын
2013 оны 03 сарын 29-ны
өдрийн 1149 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

АРХАНГАЙ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Архангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба /цаашид Алба гэх/ нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага бөгөөд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан стандарт, хөтөлбөр, нэгдсэн арга зүй, аймгийн Засаг даргын захирамж шийдвэр, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон мөрдөж ажиллана.

1.3 Алба нь санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлого зорилттой уялдуулан аймгийн Засаг даргын шууд удирдлага дор үйл ажиллагаагаа явуулна.

1.4 Албаны төсөвт зардлыг аймгийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

1.5 Алба нь тогтоосон журмын дагуу хийгдсэн бэлгэдэл, тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба төрийн санд данстай байна.

1.6 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны батлагдсан дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авна.

Хоёр. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны удирдлага, зохион байгуулалт

2.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба буюу дотоод аудитын нэгж нь төсвийн ерөнхийлөн захирагчид ажлаа хариуцан тайлагнана.

2.2 Алба нь дарга, нягтлан бодогч, ахлах дотоод аудитор, дотоод аудиторууд санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, улсын байцаагчид, хуулийн зөвлөх-ДХАМ, нярав эд хариуцагч, архив-бичиг хэргийн ажилтан, жолооч гэсэн бүтэц орон тоотойгоор үйл ажиллагаа явуулна. Албаны орон тоо, цалингийн санг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуулийн дагуу жил бүр тогтоож, зардлыг тухайн жилийн аймгийн төсөвт тусгана.

2.3 Албаны дүрмийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд баталж, албаны даргыг албан тушаалын тодорхойлолтод тусгасан шаардлага, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга нь санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн эрхтэй байх бөгөөд эрхийг Санхүүгийн хяналт шалгалтын улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр олгоно. Албаны дарга нь аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнүүлнэ.

2.4 Албаны дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах ба байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг сахиулж, ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдал, албаны хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

2.5 Албаны дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан ажилтнуудыг санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм, тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан тавигдах шаардлага, нөхцөл болзлыг хангасан иргэнийг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн томилж, чөлөөлнө.

2.6 Албаны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн Засаг дарга хянах бөгөөд албаны дарга нь байгууллагын, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг, нэгжийн дарга нь төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус баталж, албаны дарга холбогдох ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын үр дүнг бодитойгоор үнэлж дүгнэнэ.

2.7 Албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг аймгийн Засаг дарга, албаны ахлах болон дотоод аудиторуд, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нар, төрийн үйлчилгээний ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг албаны дарга холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр батлуулж, мөрдүүлнэ.

2.8. Гэрээт аудитор, үйлчилгээний ажилтан шаардлагатай тохиолдолд ажиллуулж болно. Албан байгууллагын хүрээнд шаардагдах бусад чиг үүргүүдийг ажилтан албан хаагчид "Ажил үүргийн хуваарь"-ийн дагуу гүйцэтгэнэ.

2.9. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

2.10. Алба нь дотоод журамтай байна. Хөдөлмөрийн дотоод журмыг хамт олны хурлаар хэлэлцэн батлуулж, мөрдөн ажиллана.

Гурав. Үйл ажиллагааны зорилго

3.1. Албаны үйл ажиллагааны зорилго нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах,

эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дөрөв. Үйл ажиллагааны зарчим

4.1. Албаны үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт шалгалт, аудитын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтална.

Тав. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

5.1. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах хүрээнд хийнэ.

5.1.1. хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдал, хэрэгжилтийн хяналт

5.1.2. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдал

5.1.3. Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал

5.1.4. санхүү, төсөв, төрийн сангийн үйл ажиллагааны үнэн зөв, найдвартай байдал

5.1.5. салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдал

5.1.6. төсвийн ерөнхийлөн захирагч болон тухайн байгууллагын шийдвэрээр тусгайлан явуулах аудит

5.1.7. Байгууллагын дотоод хяналт, засаглалын байдалд болон холбогдох стандартын хүрээнд тодорхойлсон бусад аудит

5.2. Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь энэхүү дүрмийн 5.1-д зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.2.1. төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих

5.2.2 тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих

5.2.3. төсвийн буюу төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын өглөг, авлагын байдалд хяналт тавих

5.2.4. Засгийн газрын тусгай сан, төсвөөс олгосон олгосон санхүүгийн тусламж дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих

5.2.5 төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих

5.2.6. анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд хяналт тавих

Зургаа. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудиторын эрх, үүрэг

6.1. Улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор нь дараах эрхтэй байна.

6.1.1 Байгууллын нэгжийн үйл ажиллагаатай танилцах

6.1.2 Холбогдох албан хаагчтай уулзалт, ярилцлага хийх

6.1.3 бичмэл болон цахим баримт, мэдээлэл, материалыг гаргуулан авах, хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэх

6.1.4 шаардлагатай бол тухайн байгууллагын байр, тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглах

6.1.5 санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахтай холбоотой баримт бичигтэй танилцах хүсэлтээ холбогдох банк, санхүүгийн байгууллагад тавих

6.1.6 өмнө хийсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэх

6.1.7 Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх

6.2. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор нь дараах үүрэгтэй байна.

6.2.1. үйл ажиллагаандаа хууль тогтоомж, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Олон улсын Дотоод аудиторуудын институтээс гаргасан дотоод аудиторын ёс зүйн дүрмийг чанд баримтлах

6.2.2. хяналт шалгалт, аудитын явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгалах

6.2.3. хяналт шалгалт, аудитын явцад танилцсан, олж авсан бүх баримт бичиг, мэдээллийг зөвхөн хяналт шалгалтын болон дотоод аудитын үйл ажиллагаанд ашиглах

6.2.4. мэргэжлийн мэдлэг, чадвараа тасралтгүй дээшлүүлэн хөгжүүлэх

6.2.5. аливаа асуудалд шударга, бодит байдалд нийцүүлэн хандаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах

6.2.6. аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар дотоод аудитын нэгжийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагчид мэдээлэх

6.3. Дотоод аудитор буюу санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь энэ дүрмийн 6.1, 6.2-т зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

6.3.1. санхүүгийн хяналт шалгалтын шалгалтын тэмдэглэл болон нэг бүрчилсэн акт, танилцуулга, аудитын зөвлөмжийг хууль тогтоомж болон баримт нотолгоонд

үндэслэн гаргах

6.3.2. хяналт шалгалтын танилцуулга, бусад баримт бичгийг /шалгалтын тэмдэглэл, нэг бүрчилсэн акт, албан шаардлага/ Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, архив бичиг хэргийн стандартын дагуу үйлдэж, гарын үсэг зурах;

6.3.3. хяналт шалгалтын тэмдэглэл, акт, албан шаардлагыг шалгуулсан этгээдэд танилцуулж, холбогдох баримт бичигт гарын үсэг зуруулах;

6.3.4. санхүүгийн хяналт шалгалтын болон аудитын материал, бичсэн танилцуулга, акт, тоо баримтын үндэслэл нотолгооны үнэн зөвийг хариуцах;

6.3.5. шалгалтын дүнд тулгуурлан гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, зохих журмын дагуу биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

6.3.6. санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх

Долоо. Хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх

7.1 Алба нь Аудитын дунд хугацааны төлөвлөгөөтэй байх бөгөөд төлөвлөгөөг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч батална.

7.2 Аудитын жилийн төлөвлөгөөнд тусгасан аудитын ажлын нэгдсэн удирдамжийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, нэгбүрчилсэн удирдамжийг төсвийн шууд захирагч буюу дотоод аудитын нэгжийн дарга батална.

7.3. Аудит, санхүүгийн хяналт шалгалтыг холбогдох олон улсын стандарт, хууль, журмыг баримтлан гүйцэтгэнэ.

7.4. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, ахлах болон дотоод аудиторуд нь аудит, хяналт шалгалтын дүнгийн талаар шалгалт дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор шалгалтын тэмдэглэл, хяналт шалгалтын танилцуулга, дотоод аудитын ажлын тайланг бичиж, албаны даргад танилцуулна. Дүнг Санхүүгийн хяналт, дотоод аудитын даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрийг хяналт шалгалт, аудит хийлгэсэн байгууллага, нэгжид хүргүүлнэ.

7.5. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, аудитор нь хяналт шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, албан тушаалтны болон төрийн байгууллагын үйл ажиллагаанд өгсөн улсын байцаагчийн дүгнэлт, санхүү төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага, дотоод аудитын ажлын тайлан, зөвлөмж бичнэ. Улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь баталж, санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосны

дагуу албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг түүнчлэн албан шаардлага, дүгнэлт, акт, зөвлөмж, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан энэхүү дүрмийн хүрээнд хэвлэмэл хуудасны эх загварыг боловсруулан хэрэглэж болно.

7.6. Дотоод аудитын нэгжийн дарга дараах асуудлыг Дотоод аудитын хороо, төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж тайлагнана.

7.6.1 гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын дүн

7.6.2 нэгжийн жилийн төлөвлөгөө түүний хэрэгжилтийн явц

7.6.3 холбогдох акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явц

7.6.4 хөндлөнгийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явц

7.6.5 хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдсан байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд анхаарах асуудал, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох санал

Найм. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын ажлын баримт, чанарын баталгаажуулалт

8.1. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг чанд баримтлах бөгөөд бүх үйл ажиллагааг баримтжуулна.

8.2. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналт, нэг бүрчилсэн акт, албан шаардлага, аудитын зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний үе шат бүрийн явцын талаар зохих стандартын дагуу ажлын баримт бэлтгэж, архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгнө.

8.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт болон уг үйл ажиллагааг баримтжуулалтад зайлшгүй хэрэглэх техник, тоног төхөөрөмж, дотоод аудитор чиг үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд бүх талаар дэмжлэг үзүүлж ажиллана.

8.4. Энэхүү дүрмийн 8.1, 8.2-т заасан ажлын баримтыг маргаан гарсан тохиолдолд санхүүгийн хяналт шалгалт, аудитын үр дүнг магадлах болон чанарын хяналтын хараат бус үнэлгээ хийхэд ашиглана.

Ес. Хараат бус байдал

9.1. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа нь бие даасан, хараат бус байдлаар явагдана.

9.2. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, ахлах болон дотоод аудитор нь хяналт шалгалт, аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга, төсвийн ерөнхийлөн захирагчид мэдээлнэ.

9.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, улсын /ахлах/ байцаагчид болон аудиторуудыг ажил үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд бүх талаар дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл боломжийг хангана.

Арав. Хөндлөнгийн аудиттай харилцах

10.1 Алба нь төрийн аудитын байгууллагатай дараах хүрээнд хамтран ажиллаж болно.

10.1.1. хамтарсан сургалт зохион байгуулах, арга зүй, туршлага солилцох

10.1.2. харилцан мэдээлэл солилцох

Арван нэг. Байгууллагын удирдлага, албан хаагчдын үүрэг

11.1. Санхүүгийн хяналт шалгалт, аудитын үйл ажиллагааг явуулах үед санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудиторын шаардсан мэдээ, материал, лавлагаа, тайлбарыг хяналт шалгалт, аудит хийлгэж байгаа байгууллага, хуулийн этгээдийн удирдлага, албан хаагчид холбогдох дүрэм, зааврын дагуу хугацаанд нь гарган өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд ярилцлага, санал асуулга явуулахад оролцоно.

11.2. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагчийн акт, албан шаардлага, гаргасан үнэлэлт, дүгнэлт, дотоод аудиторын зөвлөмжийг байгууллагын удирдлага, албан хаагчид хэрэгжүүлэх үүрэгтэй.

Арван хоёр. Бусад

12.1 Энэ дүрэмд шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн бүрэлдэхүүн хэсэг болж мөрдөгдөнө.

12.2 Энэ дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

-----ООО-----

03

Аймгийн Засаг даргын 2013 оны
..... дугаар сарын -ны өдрийн дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



АРХАНГАЙ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ БҮТЭЦ, ОРОН ТОО

Д/д	Бүтэц, албан тушаалын нэршил	Орон тоо
Захиргаа, аж ахуй:		
1	Дарга	1
	Нягтлан бодогч	1
	Архив-бичиг хэргийн ажилтан	1
Санхүүгийн хяналт шалгалт:		
2	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч	1
	Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч	1
Дотоод аудит:		
3	Ахлах дотоод аудитор	1
	Дотоод аудитор	3
НИЙТ ОРОН ТОО		9

----oOo----